**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 19 өдөр Дугаар 471 Улаанбаатар хот

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн”
төрийн өмчит үйлдвэрийн газрын
2019 оны төлөвлөгөөг шинэчлэн
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа шинэчлэгдэн цахим хэлбэрт шилжиж, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоо буурсантай холбогдуулан “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчилсэнтэй холбогдуулан 2019 оны бизнес төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр хангаж биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал М.Түмэнжаргалд үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 645 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

000097

D:\Huraldaanii material\2019 on\2019.11.19 №22.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
20019 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн
471 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## "ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2018 он | 2019 он | | Харьцуулалт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Шинэчилсэн төлөвлөгөө | 2019 шинэ.төл /2019 төл | Зөрүү (2019 шинэ.төл-2019 оны төл) |
| 1 | 2 | 3 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | | | | | | |
| | а/ Эрдэм шинжилгээ, судалгааны ажил | Биет | 271,093.9 | 307,800.0 | 307,800.0 | 100.0 | - |
| | Зураг төсөл боловсруулах ажил | Биет | 320,757.0 | 495,484.8 | 495,484.8 | 100.0 | - |
| | Норм, норматив боловсруулах | Биет | 283,172.7 | 380,000.0 | 380,000.0 | 100.0 | - |
| | Тусгай зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх ажил | Биет | 956,250.0 | 861,200.0 | 586,250.0 | 68.1 | (274,950.0) |
| | б/ Үнийн дүнгээр | мян.төг | 1,831,273.6 | 2,044,484.8 | 1,769,534.8 | 86.6 | (274,950.0) |
| 2 | Нийт орлого | мян.төг | 1,831,273.6 | 2,044,484.8 | 1,769,534.8 | 86.6 | (274,950.0) |
| | Үүнээс: цэвэр борлуулалт | мян.төг | 1,831,273.6 | 2,044,484.8 | 1,769,534.8 | 86.6 | (274,950.0) |
| 3 | Нийт зардал | мян.төг | 1,527,750.3 | 1,822,608.0 | 1,765,318.0 | 96.9 | (57,290.0) |
| | Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал | мян.төг | 59,043.9 | 64,764.3 | 54,764.3 | 84.6 | (10,000.0) |
| | Мэргэжлийн ажил үйлчилгээний зардал | мян.төг | 234,942.3 | 260,790.0 | 230,790.0 | 88.5 | (30,000.0) |
| | Тусгай зөвшөөрөл эзэмших эрх олгох бэлтгэл ажил хангах зардал | мян.төг | 181,971.8 | 116,856.0 | 101,856.0 | 87.2 | (15,000.0) |
| 4 | Татварын өмнөх ашиг | мян.төг | 303,523.3 | 221,876.8 | 4,216.8 | 1.9 | (217,660.0) |
| 5 | Цэвэр ашиг /алдагдал/ | мян.төг | 273,171.0 | 199,689.1 | 3,795.1 | 1.9 | (195,894.0) |
| 6 | Төрийн өмчийн ногдол ашиг | мян.төг | 40,254.0 | 39,937.8 | 759.0 | 1.9 | (39,178.8) |
| 7 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | мян.төг | 0.83 | 0.89 | 1.00 | 111.9 | 0.1 |
| 8 | Хөрөнгө оруулалт | мян.төг | 213,555.0 | 136,300.0 | 34,300.0 | 25.2 | (102,000.0) |
| 9 | Авлага | мян.төг | 1,281,511.8 | 120,000.0 | 120,000.0 | 100.0 | - |
| 10 | Өглөг | мян.төг | 965,243.1 | 20,000.0 | 20,000.0 | 100.0 | - |
| | Богино хугацаат өр төлбөр | мян.төг | 965,243.1 | 20,000.0 | 20,000.0 | 100.0 | - |
| | Урт хугацаат өр төлбөр | мян.төг | - | - | | | |
| 11 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 37 | 41 | 41 | 100.0 | - |
| 12 | Нийт цалингийн сан | мян.төг | 666,632.8 | 825,960.0 | 825,960.0 | 100.0 | - |
| 13 | Нэг ажиллагчийн дундаж цалин | мян.төг | 991.0 | 1,086.4 | 1,086.4 | 100.0 | - |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дүгээр сарын 19 -ны өдрийн
471. дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН"
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Бараа, ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо | Нэгж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Температурын даталогер | ш | 1 | 3,800,000.0 | 3,800,000.0 |
| 2 | Амперклеш | ш | 2 | 300,000.0 | 600,000.0 |
| 3 | Багаж | | 1 | 10,000,000.0 | 10,000,000.0 |
| 4 | Конторын барилгын 1 давхрын хаалганы гадаа металл вакуум хаалт | ш | 1 | 4,200,000.0 | 4,200,000.0 |
| 5 | Хурлын сандал | ш | 15 | 300,000.0 | 4,500,000.0 |
| 6 | Баллонтой ус цэвэршүүлэгч төхөөрөмж | ш | 4 | 550,000.0 | 2,200,000.0 |
| 7 | Барилгын сантехник /ус зайлуулах хоолой/-н засварын ажил | ш | 1 | 9,000,000.0 | 9,000,000.0 |
| **НИЙТ ДҮН** | | | | | **34,300,000.00** |